Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэгт холбогдон шалгагдсан 5507 хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42 буюу 0.8 хувиар өссөн байна. Үүнээс 372 буюу 6.8

хувь нь эмэгтэй, 5135 буюу 93.2 хувь нь эрэгтэй, тэдний 66 буюу 1.2 хувь нь хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос эмэгтэй 7.1 хувиар, эрэгтэй 6.1 хувиар, хүүхэд 12.0 хувиар тус тус буурчээ.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Гэмт хэргийн улмаас

1 аж ахуйн нэгж, байгууллага, 4855 иргэн хохирч, үүнээс 242 хүн нас барж, 3722 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 26 буюу 9.7 хувиар, гэмтсэн хүний тоо 171 буюу 4.4 хувиар тус тус буурсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 5.5 тэрбум төгрөгийн хохирлын 76.4 хувийг нөхөн төлүүлж, 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§4.2. Бүлэг, зохион байгуулалттай үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 1635 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 639 хэргээр буюу 28.1, Улаанбаатар хотын хэмжээнд 259 хэргээр буюу 20.4 хувиар тус тус буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2015	2016		2015	2016
Орон нутагт	1000	623	-37.7	44.0	38.1
Нийслэлд	1268	1009	-20.4	55.7	61.7
Бусад	6	3	-50.0	0.3	0.2

1.3. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:



1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:

Даваа	•240	14.7%
Мягмар	•239	14.6%
Лхагва	•245	15.0%
Пүрэв	•275	16.8%
Баасан	•223	13.6%
Бямба	•198	12.1%
Ням	•215	13.1%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт 89 буюу 27.1, Мягмар гарагт 79 буюу 24.8, Лхагва гарагт 116 буюу 32.1, Пүрэв гарагт 68 буюу 19.8, Баасан гарагт 99 буюу 30.7, Бямба гарагт 101 буюу 33.8, Ням гарагт 87 буюу 28.8 хувиар тус тус буурсан.

Цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд 93 буюу 25.7, 14-19 цагийн хооронд 145 буюу 29.5, 19-22 цагийн хооронд 133 буюу 39.6, 22-06 цагийн хооронд 268 буюу 24.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 2541 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 954 буюу 27.3 хувиар буурсан байна. Үүнээс 342 буюу 13.4 хувь нь эмэгтэй, 2199 буюу 86.6 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй хүн 4.7, эрэгтэй хүн 29.9 хувиар тус тус буурсан байна.

3.1 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Гэмт хэргийн улмаас

1662 иргэн, 8 байгууллага аж ахуйн нэгж хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 650 буюу 28.1 хувиар буурч, байгуулага аж ахуйн нэгж өмнөх оны түвшинд байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 11.3 тэрбум төгрөгийн хохирлын 39.3 хувийг нөхөн төлүүлж, 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§4.3. Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 33 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 5 хэргээр буюу 13.2, Улаанбаатар хотын хэмжээнд 1 хэргээр буюу 20.0 хувиар тус тус буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2015	2016		2015	2016
Орон нутагт	33	29	-12.1	0.1	0.1
Нийслэлд	5	4	-20.0	0.02	0.01

1.3. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:

Энэ төрлийн хэрэг Баянхонгорт 50.0, Хөвсгөлд 66.7 хувиар тус тус буурч, Ховдод 50.0, Сэлэнгэд 2.0 дахин, Хэнтий, Өмнөговь, Дорноговь аймгуудад тус бүр 3.0 дахин өсч, Баян-Өлгий, Увс, Төв аймаг, нийслэлийн Баянзүрх дүүрэгт өмнөх оны түвшинд, бусад аймаг, дүүргүүдэд бүртгэгдээгүй байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт 2 буюу 40.0 хувиар, Мягмар гарагт 4 буюу 2.0 дахин, Баасан гарагт 4 буюу 3.0 дахин тус тус өсч, Пүрэв гарагт 1 буюу 25.0, Бямба гарагт 9 буюу 81.8, Ням гарагт 5 буюу 71.4 хувиар тус тус буурч, Лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг өмнөх оны түвшинд байна.

Цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд 2 буюу 33.3, 19-22 цагийн хооронд 1 буюу 25.0 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд 5 буюу 31.3, 22-06 цагийн хооронд 3 буюу 25.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 34 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 буюу 27.6 хувиар буурсан байна. Үүнээс 1 буюу 2.9 хувь нь эмэгтэй, 33 буюу 97.1 хувь нь эрэгтэй хүн байна.

2.1 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Гэмт хэргийн улмаас

10 иргэн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 15 буюу 60.0 хувиар буурсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 210.0 сая төгрөгийн хохирлын 78.0 хувийг нөхөн төлүүлж, 214.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§4.4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2015	2016	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг	1356	1449	93	-2.1
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	4.9	5.3	-0.4 нэгжээр өссөн	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 83.0 хувийг хөнгөн, 11.4 хувийг хүндэвтэр, 3.5 хувийг хүнд, 2.1 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж, 57.8 хувь нь Улаанбаатар хотод, 42.2 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ.



1.3 Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

Бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 1356 буюу 93.6, танхайрах хэрэг 38 буюу 2.6, хүчиндэх хэрэг 26 буюу 1.8, хүнийг санаатай алах хэрэг 16 буюу 1.1, бусад төрлийн хэрэг 13 буюу 0.9 хувийг тус тус эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн 595 буюу 41.1 хувь нь согтуугаар, 91 буюу 6.3 хувь нь эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:



Энэ төрлийн гэмт хэрэг гэр, орон сууцанд 1249 буюу 86.2, гудамж талбайд 92 буюу 6.3, олон нийтийн газарт 34 буюу 2.3, аж ахуйн нэгжид 13 буюу 0.9, төрийн болон төрийн бус байгууллага, нийтийн тээвэрт тус бүр 1 буюу 0.1, бусад газар 58 буюу 4.0 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн хохирогч, хохирол

2.1 Гэмт хэргийн улмаас 2016 онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт 27689 иргэн өртөж хохирсноос *гэр бүлийн хүчирхийлэлд* 1357 иргэн өртөж хохирсоны 90.7 хувь нь эмэгтэй хүн байна.



Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 830, хамтран амьдрагч 229, нөхөр 74, төрсөн хүүхэд 42, дагавар хүүхэд 31, хадам эцэг, эх 20, төрсөн эцэг, эх 15, төрсөн дүү 13, төрсөн ах, эгч 13, өвөө 1, бусад 89 хүн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 1217 хүн гэмтэж, иргэдэд 851.1 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирчээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл:

2.2 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 23805 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсаны 1455 буюу 6.1 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсний учир холбогдон шалгагдаж тэдний 39.5 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдэн бүртгэгдсэн байна.





Гурав. Захиргааны зөрчил

3.1 Захиргааны зөрчлийн тоо:

Нийт 1038050 захиргааны зөрчил бүртгэгдсэний 1866 буюу 0.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж, зөрчил гаргасан 1274 хүнд 15.0 сая төгрөгөөр торгох, 592 хүнд баривчлах шийтгэлийг “Захиргааны хариуцлагын тухай хууль”-д зааснаар ногдуулсан байна.

Зөрчлийн 1809 буюу 96.9 хувийг танхайрах, 50 буюу 2.7 хувийг согтуурах, 6 буюу 0.3 хувийг цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, 1 буюу 0.1 хувийг нийтийн эзэмшлийн эд хөрөнгө эвдэх, гэмтээх зөрчил тус тус эзэлж байна.

3.2 Зөрчил үйлдэгдсэн гараг, цаг:

Даваа	•321	17.2%
Мягмар	•328	17.6%
Лхагва	•269	14.4%
Пүрэв	•270	14.5%
Баасан	•228	12.2%
Бямба	•198	10.6%
Ням	•252	13.4%



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн 92.3 хувь нь гэр, орон сууцанд, 3.2 хувь нь гудамж талбайд, 2.5 хувь нь олон нийтийн газарт, 1.0 хувь нь аж ахуйн нэгжид, 0.3 хувь нь төрийн байгууллагад, 0.1 хувь нь төрийн бус байгууллагад, 0.6 хувь нь бусад газарт тус тус үйлдэгджээ.

3.3 Зөрчил үйлдэгчдийн нас, хүйс, нийгмийн байдал:

Зөрчил үйлдэгчдийн 1831 буюу 98.1 хувь нь эрэгтэй, 35 буюу 1.9 хувь нь эмэгтэй хүн эзэлж байгаа ба 1585 буюу 84.9 хувь нь согтуугаар үйлдсэн гэж бүртгэгдсэн байна.





§4.5. Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2015	2016	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг	8830	9200	370	4.2
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	31.8	33.9	2.1 нэгжээр өссөн	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 4.4 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 6.6 хувиар тус тус өсч,
- хүнд гэмт хэрэг 13.5 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 4.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.3 Гэмт хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:



1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:

Даваа	•1492	16.2%
Мягмар	•1405	15.3%
Лхагва	•1427	15.5%
Пүрэв	•1372	14.9%
Баасан	•1323	14.4%
Бямба	•1076	11.7%
Ням	•1105	12.0%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт гэр орон сууцад үйлдэгдсэн гэмт хэрэг 27 буюу 1.8 хувиар, Бямбад 22 буюу 2.0 хувиар тус тус буурч, Мягмарт 63 буюу 4.7 хувиар, Лхагвад 127 буюу 9.8 хувиар, Пүрэвд 109 буюу 8.6 хувиар, Баасанд 31 буюу 2.4 хувиар, Нямд 89 буюу 8.8 хувиар тус тус өсчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 14-19 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 153 буюу 6.2 хувиар, 19-22 цагийн хооронд 64 буюу 4.2 хувиар, 22-06 цагийн хооронд 166 буюу 5.6 хувиар тус тус өсч, 06-14 цагийн хооронд 13 буюу 0.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэр орон сууцанд үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Зуслангийн байшинд 84 буюу 48.3 хувиар, агуулахад 13 буюу 38.2 хувиар, гараажид 23 буюу 17.4 хувиар, Хувийн байшинд 206 буюу 9.0 хувиар, орон сууцны байранд 82 буюу 4.3 хувиар, бусад 7 буюу 1.8 хувиар, орцонд 2 буюу 0.7 хувиар тус тус өсч, Амбаарт 17 буюу 12.9 хувиар, хаусанд 3 буюу 9.4 хувиар, подвальд 2 буюу 2.2 хувиар, гэрт 25 буюу 0.7 хувиар тус тус буурсан байна.

1.6 Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:

Улаанбаатар хотод 64.1 хувь нь аймгуудад 35.9 хувь нь бүртгэгдсэн байна.





Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 7602 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар өссөн байна. Үүнээс 902 буюу 11.9 хувь нь эмэгтэй, 6700 буюу 88.1 хувь нь

эрэгтэй, тэдний 340 буюу 4.5 хувь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 4.4 хувиар өсч, эмэгтэй 12.3 хувиар, хүүхэд 19.8 хувиар тус тус буурсан байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Гэмт хэргийн улмаас

4 аж ахуйн нэгж, байгууллага, 9391 иргэн хохирч, үүнээс 239 хүн нас барж, 3722 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 42 буюу 21.3 хувиар, гэмтсэн хүний тоо 115 буюу 3.2 хувиар өссөн байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 16.7 тэрбум төгрөгийн хохирлын 40.1 хувийг нөхөн төлүүлж, 0.7 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§4.6. Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2015	2016	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг	3625	3837	212	5.8
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	13.1	14.1	1.0 нэгжээр өссөн	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

-хөнгөн гэмт хэрэг 5.1 хувиар,

-хүндэвтэр гэмт хэрэг 10.5 хувиар тус тус өсч,

-хүнд гэмт хэрэг 17.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

-онц хүнд гэмт хэрэг мөн үеийн түвшинд байна.

1.3 Гэмт хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:



1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:

Даваа	•556	14.5%
Мягмар	•581	15.1%
Лхагва	•518	13.5%
Пүрэв	•539	14.0%
Баасан	•568	14.8%
Бямба	•559	14.6%
Ням	•516	13.5%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 40 буюу 6.7 хувиар буурч, Мягмар гарагт 44 буюу 8.2 хувиар, Лхагвад 34 буюу 7.0 хувиар, Пүрэвт 18 буюу 3.5 хувиар, Баасанд 39 буюу 7.4 хувиар, Бямбад 80 буюу 16.7 хувиар, Ням гарагт 37 буюу 7.7 хувиар тус тус өсчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 71 буюу 10.9 хувиар, 22-06 цагийн хооронд 197 буюу 13.7 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд 15 буюу 1.5 хувиар, 19-22 цагийн хооронд 41 буюу 8.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэргийн үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Бааранд 141 буюу 17.1 хувиар, бусад газарт 37 буюу 6.5 хувиар, бөөний худалдааны төвд 27 буюу 10.4 хувиар, амралтын газарт 22 буюу 27.5 хувиар, дэлгүүрт 7 буюу 1.1 хувиар, авто вокзал 6 буюу 25.0 хувиар, сувиллын газарт 2 буюу 20.0 хувиар, төмөр замын вокзал 15 буюу 71.4 хувиар, нисэх онгоцонд 2 буюу 50.0 хувиар, түцэнд 57 буюу 3.2 дахин тус тус өсч, Нийтийн захад 64 буюу 16.1 хувиар, зочид буудалд 19 буюу 5.0 хувиар, ресторан, зоогийн газарт үйлдэгдсэн хэрэг 10 буюу 3.4 хувиар, үзвэрийн газарт 8 буюу 16.3 хувиар, саунд 2 буюу 14.3 хувиар, жуулчны бааз 1 буюу 7.7 хувиар тус тус буурчээ.

1.6 Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:

Улаанбаатар хотод 81.4 хувь нь, аймгуудад 18.5 хувь нь бүртгэгдсэн байна.





Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 3400 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9 хувиар өссөн байна. Үүнээс 787 буюу 23.1 хувь эмэгтэй, 2613 буюу 76.9 хувь эрэгтэй, тэдний 256 буюу 7.5 хувь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс хүүхэд 10.5 хувиар буурч, эмэгтэй 3.4 хувиар, эрэгтэй 2.7 хувиар тус тус өссөн байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Гэмт хэргийн улмаас

5 аж ахуйн нэгж, байгууллага, 3936 иргэн хохирч, үүнээс 19 хүн нас барж, 1622 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 4 буюу 26.7 хувиар, гэмтсэн хүний тоо 87 буюу 5.7 хувиар тус тус өссөн байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 8.7 тэрбум төгрөгийн хохирлын 48.3 хувийг нөхөн төлүүлж, 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§4.7. Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 417 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 38 хэргээр буюу 8.4 хувиар, үүнээс Улаанбаатар хотын хэмжээнд 188 бүртгэгдсэн нь 50 хэргээр буюу 21.0 хувиар тус тус буурсан.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2015	2016		2015	2016
Орон нутагт	216	229	6.0	2.2%	2.5%
Нийслэлд	238	188	- 21.0	1.3%	1.0%
Бусад газарт	1	-	-	0.02%	-

1.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/:





1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:

Даваа	•83	19.9%
Мягмар	•74	17.7%
Лхагва	•67	16.1%
Пүрэв	•61	14.6%
Баасан	•59	14.1%
Бямба	•34	8.2%
Ням	•39	9.4%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Пүрэвд гарагт үйлдэгдсэн 19 буюу 23.8 хувиар, Баасанд 17 буюу 22.4 хувиар, Лхагвад 9 буюу 11.8 хувиар, Даваад 6 буюу 6.7 хувиар, Мягмарт 2 буюу 2.6 хувиар тус тус буурч, Ням гарагт үйлдэгдсэн 8 буюу 25.8, Бямбад 7 буюу 25.9 хувиар тус тус өссөн байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд 39 буюу 17.5 хувиар, 14-19 цагийн хооронд 24 буюу 15.8 хувиар буурч, 22-06 цагийн хооронд 19 буюу 37.3 хувиар 19-22 цагийн хооронд 6 буюу 20.7 хувиар, тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: захиргааны байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 32 буюу 30.8 хувиар, цагдаад 16 буюу 25.8 хувиар, ШШГүйцэтгэх 10 буюу 33.3 хувиар, прокурор 4 буюу 57.1 хувиар, бүртгэлийн газарт 4 буюу 23.5 хувиар, татварын газарт 3 буюу 50.0 хувиар, дипломат төлөөлөгчийн газар 2 буюу 100 хувиар, шүүхэд 1 буюу 6.3 хувиар, дотоодын цэрэг 1 буюу 100 хувиар, хилийн цэрэгт 1 буюу 16.7 хувиар, ашигт малтмалын газар 1 буюу 50.0 хувиар тус тус буурсан

Бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 13 буюу 9.2 хувиар, гаалийн газар 16 буюу 69.6 хувиар, онцгой байдлын газар 1 буюу 50.0 хувиар, халамж үйлчилгээний газар 1 буюу 14.3 хувиар, газрын албанд 1 буюу 50.0 хувиар тус тус өссөн

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг

-114 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1.0 хувиар өсч,

-түүнээс 74 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн,

-илрүүлэлт 64.9 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 3.6 нэгжээр өссөн байна.



Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 341 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 буюу 6.3 хувиар буурсан байна.

Үүнээс 77 буюу 22.6 хувь нь эмэгтэй, 264 буюу 77.4 хувь нь эрэгтэй, тэдний 15 буюу 4.4 хувь нь 16-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 25.2 хувиар, эрэгтэй 1.0 дахин, хүүхэд 0.7 дахин тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Гэмт хэргийн улмаас:

326 иргэн хохирч, үүнээс 8 хүн нас барж, 94 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 6 буюу 42.8, гэмтсэн хүний тоо 10 буюу 9.6 хувиар тус тус буурсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 3481,2 сая төгрөгийн хохирлын 85.7 хувийг нөхөн төлүүлж, 116.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§4.8. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Гудамж талбайг үйлдэгдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 5479 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 20 хэргээр буюу 0.4 хувиар, үүнээс Улаанбаатар хотын хэмжээнд 4060 бүртгэгдсэн нь 55 хэргээр буюу 1.4 хувиар тус тус буурсан.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2015	2016		2015	2016
Орон нутагт	1487	1415	-7.9	15.2%	15.3%
Нийслэлд	4005	4060	-1.4	22.3.%	22.7%
Бусад газарт	7	4	0.5 дах	17.9%	11.1%

1.3. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:





1.4 Гэмт хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:

Даваа	•842	15.4%
Мягмар	•812	14.8%
Лхагва	•770	14.0%
Пүрэв	•813	14.8%
Баасан	•793	14.5%
Бямба	•773	14.1%
Ням	•676	12.3%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн 73 буюу 8.0 хувиар, Лхагвад 41 буюу 5.1 хувиар, Мягмарт 33 буюу 3.9 хувиар, Пүрэвд 31 буюу 3.7 хувиар тус тус буурч, Баасанд 4 буюу 0.5 хувиар, Нямд 37 буюу 5.8 хувиар, Бямбад 117 буюу 17.8 хувиар тус тус өссөн байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 19-22 цагийн хооронд 74 буюу 7.1 хувиар, 06-14 цагийн хооронд 53 буюу 6.5 хувиар, 14-19 цагийн хооронд 31 буюу 2.3 хувиар тус тус өсч 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 21 буюу 0.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: орон сууцны хороололын гудамжинд үйлдэгдсэн хэрэг 70 буюу 4.2 хувиар, автобусны буудал дээр үйлдэгдсэн хэрэг 30 буюу 7.4 хувиар, тоглоомын талбайд үйлдэгдсэн хэрэг 21 буюу 30.0 хувиар буурсан, цэцэрлэгт хүрээлэнд үйлдэгдсэн хэрэг 15 буюу 28.3 хувиар, төмөр замын талбай дээр үйлдэгдсэн хэрэг 2 буюу 22.2 хувиар тус тус буурч, бусад газарт үйлдэгдсэн хэрэг 60 буюу 8.4, гэр хороололын гудамжинд үйлдэгдсэн хэрэг 51 буюу 2.5 хувиар, ил зогсоол дээр үйлдэгдсэн хэрэг 7 буюу 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг

-3369 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6.8 хувиар буурч,

-түүнээс 2253 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн,

-илрүүлэлт 66.8 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 1.1 нэгжээр өссөн байна.



Гурав. Гэмт хэрэгт холбогдогчид

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 4944 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 183 буюу 3.6 хувиар буурсан байна. Үүнээс 525 буюу 10.6 хувь нь эмэгтэй, 4419 буюу 89.4 хувь нь эрэгтэй, тэдний 312 буюу 6.3 хувь нь 16-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 0.5 хувиар, эрэгтэй 0.3 хувиар тус тус өсч, хүүхэд 1.5 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Гэмт хэргийн улмаас

1 аж ахуйн нэгж, байгууллага, 5660 иргэн хохирч, үүнээс 70 хүн нас барж, 3031 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 6 буюу 9.3. хувиар өсөж, гэмтсэн хүн 14 буюу 0.5 хувиар буурсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 8854.1 сая төгрөгийн хохирлын 47.1 хувийг нөхөн төлүүлж, 1032.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



ТАВ. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ

§5.1. Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 3516 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 266 хэргээр буюу 7.0 хувиар, Улаанбаатар хотын хэмжээнд 100 хэргээр буюу 2.7 хувиар тус тус буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2015	2016		2015	2016
Орон нутагт	1136	977	-14.0	11.6	10.5
Нийслэлд	2636	2536	-3.7	20.2	19.7
Бусад газарт	10	3	-70.0	0.03	0.01

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

-хөнгөн гэмт хэрэг 2.8 хувиар,

-хүндэвтэр гэмт хэрэг 11.9 хувиар,

-хүнд гэмт хэрэг 17.7 хувиар,

-онц хүнд гэмт хэрэг 21.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.3 Гэмт хэргийн бүтэц, төрлөөр:

Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 45.0 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 34.2 хувь нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 12.5 хувь нь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн 11.9 хувь нь, аж ахуйн эсрэг гэмт хэргийн 9.2 хувь нь, хүнийг санаатай алах гэмт хэргийн 8.0 хувь нь, танхайрах гэмт хэргийн 7.2 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 6.3 хувь нь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 3.4 хувь нь, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн 2.1 хувь нь эмэгтэй хүн үйлдсэн хэрэг бүртгэгджээ.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 99 буюу 14.6 хувиар, Мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 76 буюу 12.2 хувиар, Пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 62 буюу 11.1 хувиар, Баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 49 буюу 8.3 хувиар, Лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 27 буюу 4.7 хувиар, Бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 8 буюу 1.9 хувиар тус тус буурч, Ням гарагт үйлдэгдсэн хэрэг 55 буюу 15.8 хувиар өссөн байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 22-06 цагийн хооронд 93 буюу 11.8 хувиар, 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 93 буюу 8.0 хувиар, 19-22 цагийн хооронд 38 буюу 7.2 хувиар, 14-19 цагийн хооронд 43 буюу 3.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Нийтийн тээвэрт 26 буюу 55.3 хувиар, төрийн байгууллагад 33 буюу 26.8 хувиар, төрийн бус байгууллагад 14 буюу 16.5 хувиар, гэр орон сууцанд 151 буюу 14.7 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагад 53 буюу 8.6 хувиар, гудамж талбайд 18 буюу 3.3 хувиар, авто замд 2 буюу 0.9 хувиар тус тус буурч, бусад газарт 12 буюу 3.1 хувиар, олон нийтийн газарт 19 буюу 2.5 хувиар тус тус өссөн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэгт 3592 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 5.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс 1165 буюу 32.4 хувийг 14-17 насны хүүхэд эзэлж байна.

2.2 Нас, нийгмийн байдал:



Нас



Нийгмийн байдал

Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Гэмт хэргийн улмаас :

2063 иргэн хохирч, үүнээс 10 хүн нас барж, 879 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 173 буюу 7.7 хувь, гэмтсэн хүн 71 буюу 7.1 хувь тус тус буурч, нас барсан хүн 8 буюу 19.0 хувиар өссөн байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 11.5 тэрбум төгрөгийн хохирлын 40.9 хувийг нөхөн төлүүлж, 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

§5.2. Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2015	2016	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэрэг	1144	970	174	-15.2
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	4.1	3.6	-0.5	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

-хөнгөн гэмт хэрэг 15.1 хувиар
-хүндэвтэр гэмт хэрэг 14.4 хувиар
-хүнд гэмт хэрэг 3.2 хувиар
-онц хүнд гэмт хэрэг 62.5 хувиар тус тус буурсан байна.

1.3 Хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

Хүнийг санаатай алах гэмт хэргийн 0.2 хувь нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 18.5 хувь нь, хүчиндэх гэмт хэргийн 2.0 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 55.4 хувь нь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 1.9 хувь нь, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн 8.5 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 4.3 хувь нь, танхайрах гэмт хэргийн 3.6 хувь нь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн 1.3 хувьд, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах хадгалах, тээвэрлэх, илгээх борлуулах гэмт хэргийн нь 0.7 хувьд нь, бусад төрлийн хэрэгт 3.5 хувь үйлдэгджээ.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг:

Даваа	•161	16.6%
Мягмар	•143	14.7%
Лхагва	•127	13.1%
Пүрэв	•159	16.4%
Баасан	•138	14.2%
Бямба	•127	13.1%
Ням	•115	11.9%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 23 буюу 12.5 хувиар, Мягмарт 38 буюу 21.0 хувиар, Пүрэвт 12 буюу 7.0 хувиар, Баасанд 30 буюу 17.9 хувиар, Бямбад 20 буюу 13.6 хувиар, Лхагвад 41 буюу 24.4 хувиар, Ням гарагт 10 буюу 8 хувиар тус тус буурсан байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 54 буюу 24.0 хувиар, 14-19 цагийн хооронд 45 буюу 14.3 хувиар, 19-22 цагийн хооронд 43 буюу 24.2 хувиар, 22-06 цагийн хооронд 32 буюу 7.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 80 буюу 22.2 хувиар, нийтийн тээвэрт 10 буюу 71.4, төрийн бус байгууллагад 1 буюу 5.0 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагад 17 буюу 18.5 хувиар, олон нийтийн газарт 7 буюу 3.2 хувиар, авто замд 6 буюу 27.3 хувиар, төрийн байгууллагад 1 буюу 6.6 хувиар, гудамж талбайд 55 буюу 17.6 хувиар тус тус буурч, бусад газарт 3 буюу 3.4 хувиар өссөн байна.

1.6 Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:

Насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 970 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 174 хэргээр буюу 15.2 хувиар, Улаанбаатар хотын хэмжээнд 83 хэргээр буюу 12.2 хувиар тус тус буурсан байна.





Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 1165 хүүхэд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 237 буюу 16.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт холбогдогчийн 116 буюу 9.9 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 буюу 16.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Гэмт хэргийн улмаас

329 иргэн хохирч, үүнээс 4 хүн нас барж, 110 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 3 буюу 42.9 хувиар, гэмтсэн хүний тоо 53 буюу 32.5 хувиар тус тус буурсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 356.7 сая төгрөгийн хохирлын 79.4 хувийг нөхөн төлүүлж, 62.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§5.3. Гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2015	2016		2015	2016
Орон нутагт	23	13	-43.5%	27.4%	22.4%
Нийслэлд	60	45	-25.0%	71.4%	77.6%
Бусад газар	1			1.2%	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангиллаар:



Гадаадын иргэдээс үйлдэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:
- хөнгөн гэмт хэрэг 34.3,
- хүнд гэмт хэрэг 54.5,
- онц хүнд гэмт хэрэг 61.5 хувиар тус тус буурч,
- хүндэвтэр гэмт хэрэг өмнөх оны түвшинд байна.

1.3 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн төрлөөр/:

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг 2015 он	2016 он	Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь
	1	-	0.0	-
	26	18	-30.8	31.0
	3	7	2.3 дахин	12.0
	18	6	-66.7	10.3
	5	2	-60.0	3.5
	3	2	-33.3	3.5
	7	8	14.3	13.8
	2	3	50.0	5.2
	19	12	-36.8	20.7

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг:

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг:



1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Аж ахуйн нэгж, байгууллагад 8 буюу 42.1 хувиар, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 3 буюу 21.4 хувиар, гудамж талбайд 7 буюу 63.6 хувиар, олон нийтийн газарт 4 буюу 33.3 хувиар, авто замд 2 буюу 18.2 хувиар, бусад газарт 2 буюу 15.4 хувиар тус тус буурч, төрийн байгууллагад, төрийн бус байгууллагад мөн үеийн түвшинд байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан гадаадын иргэд:

Нийт гадаадын 63 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 иргэн буюу 32.0 хувиар буурсан байна. Үүнээс 11 буюу 17.5 хувь нь эмэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн, 52 буюу 82.5 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35 буюу 6.1 хувиар өссөн байна.

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн	92	63	-29	-32.0

2.2 Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэдийн иргэншил:

Монгол Улсын нутаг дэвсгэрт 2016 онд гадаадын 63 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны дотор БНХАУ-ын 36, ОХУ-ын 8, БНСУ-ын 7, АНУ-ын 4, Унгар 2, Япон, Вьетнам, ХБНГУ, Израиль, Нигер, Казакстан улсын тус бүр нэг иргэн байна.

2.3 Нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэд

3.1 Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэд:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэн	193	148	-45	-23.3

3.2 Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэний иргэншил:

Гадаадын 148 иргэн гэмт хэрэгт өртөж хохирсоны дотор БНХАУ-ын 64, БНСУ-ын 24, ОХУ-ын 13, Вьетнам улсын 9, АНУ-ын 6, ХБНГУ-ын 5, Япон, Турк улсын тус бүр 4, Франц улсын 3, Энэтхэг, Малайз улсын тус бүр 2, Австрали, Армени, Украин, Перу, Польш, Австри, Швейцар, Шинэ Зеланд, Бельги, Их Британи, Итали, Унгар улсын тус бүр нэг иргэн байна.

3.3 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал:



Гурав: Захиргааны зөрчилд холбогдон шалгагдсан болон өртсөн гадаадын иргэд

Захиргааны зөрчлийн улмаас гадаадын 16 иргэн өртөж хохирсоны дотор АНУ, ОХУ-ын тус бүр 3 иргэн, БНХАУ, БНСУ, ХБНГУ-ын тус бүр 2 иргэн, Итали, Кувейт, Казакстан, Беларусь улсын тус бүр нэг иргэн байна.

Захиргааны зөрчилд гадаадын 879 иргэн холбогдон шалгагдсан байна. Нийт зөрчлийн 663 буюу 75.4 хувь нь Улаанбаатар хотод, 216 буюу 24.6 хувь нь орон нутагт үйлдэгдсэн гэж бүртгэгджээ.

Хуулийн нэр	График	Тоо	Хувь
Захиргааны хариуцлагын тухай		430	48.9%
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай		424	48.2%
Тамхины хяналтын тухай		18	2.0%
Архидан согтуурахтай тэмцэх тухай		3	0.4%
Галт зэвсгийн тухай		3	0.4%
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай		1	0.1%

Зөрчил гаргасан 796 иргэнд торгох, 83 иргэнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулжээ.

§5.4. Урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Гэмт хэрэг үйлдсэн урьд нь ял шийтгэгдсэн хүн:

2016 онд урьд нь ял шийтгэгдсэн 1608 хүн гэмт хэрэгт холбогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 153-оор буюу 10.5 хувиар өссөн. Нийт гэмт хэрэгт холбогдсон хүмүүст эзлэх хувийн жин 6.8 хувь байна.

1.2 Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:

Улаанбаатар хотод 61.5 хувь нь, аймгуудад 38.5 хувь нь бүртгэгдсэн байна.





1.3 Бүртгэгдсэн гэмт хэргийн /гэмт хэргийн төрлөөр/:

- 2 буюу 0.1 хувь нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 6 буюу 0.4 хувь нь прокурорын хяналт, шүүх, цагдан хорих ангиас оргох,
- 4 буюу 0.3 хувь нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах,
- 23 буюу 1.4 хувь нь бусдын эд хөрөнгийг булаах,
- 4 буюу 0.3 хувь нь төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх, доромжлох,
- 20 буюу 1.2 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 23 буюу 1.4 хувь нь хүнийг санаатай алах,
- 5 буюу 0.3 хувь бусдыг амиа хорлоход хүргэх,
- 27 буюу 1.7 хувь нь хүчиндэх,
- 2 буюу 0.1 хувь нь биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохин байгуулах,
- 1 буюу 0.06 хувь нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах,
- 2 буюу 0.1 хувь нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомж зөрчих,
- 60 буюу 3.7 хувь нь дээрэмдэх,
- 91 буюу 5.7 хувь нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах,
- 96 буюу 5.9 хувь нь танхайрах,

- 321 буюу 20.0 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 861 буюу 53.5 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 60 буюу 3.7 хувь нь бусад төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагджээ.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 1608 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 153 буюу 10.5 хувиар өссөн байна. Үүнээс 91 буюу 5.7 хувь нь эмэгтэй, 1517 буюу 94.3 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 6.2 хувиар буурсан, эрэгтэй 11.7 хувиар өссөн байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, нийгмийн байдал



Гурав. Захиргааны хяналтанд байгаа хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

1.1 Гэмт хэрэг үйлдсэн захиргааны хяналтанд байсан хүн:

2016 онд захиргааны хяналтанд байсан 101 хүн гэмт хэрэгт холбогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 43 буюу 29.9 хувиар буурсан, нийт гэмт хэрэгт холбогдсон хүмүүст эзлэх хувийн жин 0.4 хувь байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /гэмт хэргийн төрлөөр/:

- 3 буюу 3.0 хувь нь хүнийг санаатай алах, 2 буюу 2.0 хувь нь хүчиндэх,

- 1 буюу 0.1 хувь нь прокурорын хяналт, шүүх, цагдан хорих ангиас оргох, 9 буюу 8.9 хувь нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах,

- 1 буюу 0.1 хувь нь төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх,

- 2 буюу 2.0 хувь нь дээрэмдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,

- 9 буюу 8.9 хувь нь танхайрах,

- 18 буюу 17.2 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах,

- 50 буюу 49.5 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлах,

- 2 буюу 2.0 хувь нь бусад төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагджээ.

ЗУРГАА. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэг.Засгийн газар

❖ Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг багасгах замаар ядуурлын түвшин, ажилгүйдлээс үүдэлтэй шилжилт хөдөлгөөнийг бууруулах, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх уриалгыг гаргаж, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх;

❖ Хүн амын шилжилт хөдөлгөөн, ажилгүйдлийг зохицуулах хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барих. Энэ хуулийн төсөлд хүн амын оршин суух нутаг дэвсгэрийн ложистик төлөвлөлт, иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээ, тухайн оршин суугчдад дунджаар ногдох ажлын байрны доод хязгаарыг зааж, түүнийг хэрхэн хангах талаар зохицуулсан байх;

❖ Нийгмийн эмзэг бүлэг, тэнэмэл амьдралтай, орон гэргүй, архаг архичин, мансуурах донтой, хорихоос суллагдсан хүмүүсийг эмчлэх, нийгэмшүүлэх, бусад хэлбэрээр туслалцаа үзүүлэх Үндэсний төв болон төвлөрсөн асрамжийн газруудыг байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

❖ Хүч хэрэглэсэн гэмт хэргийн 60 хувийг согтуугаар үйлдэж, иргэдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа тул нийт нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар үйлчлэх аж ахуйн нэгж (цэг)-ийн дээд хязгаарыг зааж өгөх, үүний тулд тухайн нутаг дэвсгэрт оршин суугчийн тоон үзүүлэлтийг харгалздаг байх;

❖ Гэмт хэрэг үйлдэхэд ашиглаж болзошгүй автомат тоглоом гм бараа бүтээгдэхүүнийг холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох;

❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг чадавхжуулах, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх чиглэлээр жил бүр Засгийн газрын тусгай сангаас хөрөнгө гаргах.

Хоёр.Хууль зүй, дотоод хэргийн салбар

❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах үйл ажиллагаа явуулахад учирч буй бэрхшээлийг шийдвэрлэж, хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх дүрэм журмыг УИХ, Засгийн газарт өргөн барих;

❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, дэд зөвлөлийн үүрэгт ажилд дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд хамтарч ажиллах бодлогыг тодорхойлох;

❖ Зарим төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд салбарын яамдуудтай гэрээ, санамж бичгийг байгуулж, хамтарсан арга хэмжээ, судалгаа, төлөвлөлтийг уялдуулан зохион байгуулах;

❖ Зам, гудамж талбай, нийтийн үйлчилгээний газруудад нэгдсэн стандарт бүхий CCTV системийг нэвтрүүлэх, цагдаа, хууль сахиулах байгууллагын техник, технологийн бодлогыг тодорхойлох, дэмжлэг үзүүлэх.

❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаа, хууль сахиулах байгууллагаас явуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл солилцох, бусад хэлбэрээр хамтран ажиллах;

❖ Цагдаагийн үйлчилгээний чанар, хүртээмж, жишиг нормативийг хангуулж ажиллуулах, учирч буй бэрхшээлийг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх.

Гурав.Нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд

❖ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний харъяа байгууллагуудыг нийтлэг үүргийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж хүлээх үүрэг хариуцлагыг нь нэмэгдүүлэх;

❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сум, баг, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарын оролцоог хангах, улирал тутам сургалт, зааварчилга өгдөг байх;

❖ Ял шийтгэгдсэн, хорихоос суллагдсан иргэдийг нийгэмшүүлэх, нийгмийн үйлчилгээ авахад нь туслах, ажлын байраар хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулах, ажилгүй иргэдийг аж ахуйн нэгж, байгууллагад ажилд зуучлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

❖ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, судалгааны үр дүнг ашиглан ажил, арга хэмжээ зохион байгуулах дадал хэвшлийг төлөвшүүлж үлгэрлэн ажиллах;

❖ Иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны талаар сурталчлах, соён гэгээрүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын график төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх;

❖ Нийслэл хот, төв суурин газарт шинээр баригдах барилга байгууламж, орон сууцны хорооллын зураг төслийг батлах шалгуур үзүүлэлтэд дохиолол, гадна, дотны орчинг хянах телекамерийн хяналтын системтэй байх шаардлагыг тусгаж оруулах.

Дөрөв.Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, олон нийт

❖ Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулах чиглэлээр цагдаагийн байгууллагаас тавьсан мэдэгдэл, шаардлагыг хангаж ажиллах, хариуцсан орчиндоо аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах, түүнчлэн нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулахдаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх;

❖ Аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагууд өөрийн үйл ажиллагааны явцад мэдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад өгөх, тус тусын судалгаа, тоо баримт, ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний талаар мэдээлэл хуваалцах;

❖ Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй хөршийн хяналт, оюутан цагдаа, school police зэрэг хөтөлбөр арга хэмжээнд идэвхитэй оролцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгч буй санамж, зөвлөгөөг ахуй амьдралдаа мөрдлөг болгох.

Тав.Цагдаагийн ерөнхий газар

❖ Хууль зүй, дотоод хэргийн яамнаас баримталж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын бодлогын хэрэгжилтийг хангах, бусад яам, агентлагуудад энэ төрлийн ажил, арга хэмжээ зохион байгуулахад мэргэжил, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлэх;

❖ Төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чиглүүлэх, хяналт тавих, мэдээлэл нэгтгэн боловсруулж, судалгаа, үнэлгээ, шинжилгээ хийх;

❖ Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээний жишиг нормативын дагуу нэгж, алба хаагчдын ачааллыг тэнцвэржүүлэх, чадавхижуулах, ачаалал ихтэй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын орон тоог нэмэх, алба хаагчдыг сэлгэн ажилуулах, уян хатан зохицуулалт хийх;

❖ Гэмт хэрэг, зөрчлийн дуудлагад богино хугацаанд очих, хэргийн газрын үзлэгийг чанартай явуулах, иргэдээс гомдол, мэдээлэл хүлээн авах аппликейшн бий болгох зэргээр хууль сахиулах тодорхой ажиллагааг явуулах техник, технологийн арга, аргачлалыг судалж, нэвтрүүлэх.

❖ Зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, олон талт хамтын ажиллагаа, тухайлбал:үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр байгууллага, улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх санал санаачлагыг гаргаж, шийдвэрлүүлэх.

Зургаа.Цагдаагийн мэргэшсэн албад

❖ Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж гэр бүлийн хүчирхийлэл, байгаль хамгаалах журмын эсрэг, мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим зэрэг зарим төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, шалган зааварчлах;

